

ЭДИЙН ЗАСАГ,
ХУУЛЬ ЗҮЙ

**НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН
ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАГА ХУРАЛ: ХУВЬСАЛТ ХЭТИЙН
ТӨЛӨВ**

Х. Хулан Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Улс төрийн шинэ сэтгэлгээ, орчин үеийн олон улсын харилцааг бүс нутгийн бүрэлдэхүүн хэсгийнх нь диалектик нэгдмэл байдалтай холбож үзэхийг шаардаж байна. Номхон далайг тойрсон буюу мөнхүү далайн арлуудад байрласан орнууд, эсвэл тийм орнуудын хэсгийг багтаасан Номхон далайн бүс нутаг сүүлийн үед дээрх байдлыг сүрхий онцлог шинжтэй болгож байна. Удаан хугацааны турш дэлхийн хөгжлийн гол чиглэлээс нэлээд тасархай юм шиг оршин тогтнож байсан энэ бүс нутаг олон улсын харилцааны эдийн засгийн түргэн өсөлттэй нэгэн төв, эдийн засгийн болон улс төрийн зөрөлдөөний стратегийн тавцан болохоо улам идэвхтэй харуулж ирлээ.

Тус бүс нутгийн эдийн засгийн болон стратегийн цаашдын өсөлтийн хэтийн төлөвийг гадаадын мэргэжилтнүүд «Номхон далайн хамтын нийгэмлэг», хожим нь «Номхон далайн хамтын ажиллагаа» гэж нэршсэн нэгэн төрлийн хоршмол бүлэглэлийг зохион байгуулах боломжтой холбож үзэх болов.

Бүс нутгийн орнуудын чадавхийг дээд зэргээр дайчилж, олон улсын хөдөлмөрийн байнгын хуваарийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн энэ бүсийн эдийн засгийн хэд хэдэн байгууллагад «Номхон далайн хамтын ажиллагаа»-ны баримтлал практик илрэлээ олж байна. «Номхон далайн хамтын ажиллагаа» -ны хүрээнд багтсан бүс нутгийн нэг гол байгууллага бол Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал (ПЕКК) мөн. Энэ бага хурлынхны анхны уулзалт 1980 онд Канберра хотноо болсон бол 6-р чуулган нь 1988 оны 5-р сард Осака хотод болжээ. Ингэснээр Номхон далайн орнуудын хамтын ажиллагаа нь төлөвлөгөө, үзэл баримтлалаа боловсруулах шатнаас тэдгээрийг практик дээр эрчимтэй хэрэгжүүлэх шатанд шилжив.

Анхан шатны эрмэлзэл, төлөвлөгөө

Номхон далайн орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн аливаа бүлэглэл буюу хамтын нийгэмлэг байгуулах эрмэлзэл дэлхийн хоёр дугаар дайны ч өмнө гарч байсан юм. Харин Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны нэлээд төлөвшсөн тодорхой үзэл баримтлал дайны дараа*, ялангуяа 60—70-аад оны үед бий болсон билээ. Дэлхийн улс төрийн бодлогын «зангилгааг» Европ, Атлантын далайн сав газраас Ази, Номхон далайн сав газар луу шилжүүлэх тухай үзэл баримтлалыг 60—70-аад оны зааг дээр Европын улс төрийн зүтгэлтэн А. Дуглас Хьюм (Их Британийн гадаад яамны сайд) Кувде Мюрвиль (Францын ерөнхий сайд, гадаад яамны сайд), японы зүтгэлтэн Т. Адати (тус орны худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч), Э. Сато (ерөнхий сайд), америкийн улс төрийн бод-

*Дэлхийн хоёрдугаар дайны дараа «Номхон далайн орнуудын нэгдэл»-ийн тухай санааг 1959 онд Японы парламентын доод танхимын дарга И. Коно анх гаргаж ирсэн юм. «Япон-америкийн харилцааг тэнцвэрийн байдалд оруулан, Азийн хоцрогдмол нутгийн эдийн засгийн хөгжлийг хангахын тулд Азийн эдийн засгийн эвслийг АНУ, Канадын эдийн засгийн хамтын нийгэмлэгтэй шууд харилцаатай болгууштай байна» гэж хэлжээ.¹

логотон Э. Рейшауэр, Г. Кан, Зб. Бжезинский нар дэвшүүлэн хөгжүүлсэн юм. «Номхон далайн хамтын нийгэмлэг» буюу «Номхон далайн хамтын ажиллагаа»-ны үзэл баримтлалыг боловсруулахад ялангуяа японы улс төрийн бодлоготон, мэргэжилтнүүд ихээхэн хувь нэмэр оруулав.

Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЭЗХН) хүрээнд Европын бүс нутгийн хамтын ажиллагааг зохион байгуулж эхэлсэн нь дээрх үзэл баримтлалын эрлийг идэвхжүүлсэн билээ. Хитоцубашийн их сургуулийн эдийн засгийн ухааны профессор Киёми Кожима ЕЭЗХН-ийн үлгэр жишээ болгон авч, Японы эдийн засгийн судалгааны төвөөс 1965 онд хуралдуулсан хөгжиж байгаа орнуудын худалдаа, хөгжлийн бага хурал дээр үг хэлэхдээ «Номхон далайн чөлөөт худалдааны бүс»-ийг зохион байгуулах санал тавьсан юм. Зохиогчийн саналаар уг бүсэд АНУ, Канад, Япон, Австрали, Шинэ Зеланд орох ёстой байлаа. Ингэхдээ тус байгууллагад орсон орнуудын хооронд чөлөөт худалдаа дэлгэрүүлж, гаалийн аливаа хоригийг бүрэн устгах төлөвлөгөө зохиосон байна. Харин уг байгууллагад элсээгүй орнуудын талаар явуулах эдийн засгийн бодлого гишүүн орны засгийн газрууд биеэ дааж тодорхойлох ёстой байлаа². Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Японы үндэсний хорооны гүйцэтгэгч захирал Кумао Канеко дурьдсан саналыг өндөр үнэлсэн боловч Европтой зэрэгцүүлэхэд Номхон далайн орнууд түүхийн болон соёлын хөгжил, эдийн засгийн өсөлтийн нөхцөлөөрөө хоорондоо маш ялгаатай учраас энэ Европын загварыг ойрын ирээдүйд шууд хэрэгжүүлэх боломжгүй гэж үзжээ³. Гэвч Кожимагийн санаа Японы шинжлэх ухаан, үйлдвэр, худалдаа, улс төрийн зүтгэлтний дунд зохих дэмжлэг олсон юм. 60-аад оны үед Японы гадаад яамны сайд байсан Такео Мики «Номхон далайн чөлөөт худалдааны бүс»-ийн тухай санааг хөгжиж байгаа орнуудад Японоос үзүүлэх тусламжийн тухай асуудалтай холбож, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны үзэл баримтлалыг «дайныг үгүйсгэх» улс төрийн агуулгатай болгох хэрэгтэй гэж үзэж байв⁴. Ийм чиглэлийн нэгэн алхам бол Японы эдийн засгийн судалгааны төвийн санаачилгаар Номхон далайн орнуудын худалдаа хөгжлийн бага хурал (ПАФТАД) -ын хүрээнд 1968 оны 1-р сард зохиосон анхны уулзалт юм. Бага хурлын санааг хэрэгжүүлэхэд дээр нэрлэсэн К. Кожима болон австралийн эрдэмтэн П. Дрисдейл идэвхтэй үүрэг гүйцэтгэжээ. Харин «Номхон далайн чөлөөт худалдааны бүс» гэгчид хөгжиж байгаа орнуудыг зөвхөн нэгдсэн гишүүнээр элсүүлэх боломжтой гэж үзэж байсан бол бага хуралд хөгжиж байгаа орнуудыг бүрэн эрхт гишүүнээр анхнаасаа элсүүлэхээр төлөвлөж байв. «Номхон далайн чөлөөт худалдааны бүс»-ийн үзэл баримтлалыг цаашид боловсруулснаар бага хурлын (ПАФТАД) хүрээнд 1975 онд зохиосон 7-р уулзалт дээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ОЕСД) загвараар Номхон далайн худалдаа, хөгжлийн байгууллагыг (ОПТАД) байгуулах санал тавьсан байна. АНУ-ын сенатын гадаад хэрэг эрхэлсэн хорооны Дорнод Ази, Номхон далайн хэргийн салбар хороонд зориулан П. Дрисдейл, америкийн Иелийн их сургуулийн профессор Хью Патрик нарын бэлтгэсэн илтгэлд Номхон далайн худалдаа, хөгжлийн байгууллага байгуулах тухай санааг улам нарийвчлан боловсруулсан билээ. Энэ илтгэлийн дагуу Номхон далайн худалдаа хөгжлийн байгууллага өмнөө дор дурьдсан дөрвөн үндсэн зорилго тавих ёстой байлаа. Үүнд:

1. Бүс нутгийн орнууд бие биеэсээ ихээхэн харилцан хамаардагийг харгалзан Номхон далайн орнуудын худалдаа, эдийн засгийн асуудлыг үр ашигтай хэлэлцэх хүрээг хангах;

2. Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж байгаа орнуудад тусламж үзүүлэх программ, хөрөнгө оруулалтыг дэмжиж, Номхон далайн хөгжиж байгаа орнуудад үзүүлэх тусламж, хөрөнгө оруулалт, худалдааны бүтэц, чанарыг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын хэлбэрийг бий болгох;

3. Бүс нутгийн удаан хугацааны үйл явц, эдийн засгийн өөрчлөлтийн талаар зөвлөж маргах хурлыг бий болгох;

4. Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн холбооны бат бүтэц бий болгох.⁵

Бүс нутгийн ирээдүйн бүлэглэлд оролцох хөгжингүй капиталист орнуудын үйлдвэр, худалдааны эрх баригчид дээрх хоёр эрдэмтний боловсруулсан үзэл баримтлалыг дэмжсэн билээ. Японы, тухайлбал Японы худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга Шигео Наганогийн санаачлагаар 1967 онд бүс нутгийн хөгжингүй капиталист орон Австрали, Канад, Япон, Шинэ Зеланд, АНУ-ын үйлдвэр худалдааны эрх баригчдыг оролцуулсан олон улсын байгууллага Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөлийг (ПВЕК) байгуулав. Хожим нь энэ байгууллагад Зүүн Өмнөд Ази, Латин Америкийн хөгжиж байгаа хэд хэдэн орон элсч, гишүүдийнх нь тоо 16 болжээ. Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөл Номхон далайн хөгжингүй таван орон болон Филиппин, Перуд товчоогоо байгуулж, жил бүр бага хурлаа хуралдуулж байна. Тус байгууллагын 21-р бага хурлыг 1988 оны 5-р сард Сидней хотноо хуралдуулжээ.

Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал үүсч хөгжсөн нь

«Номхон далайн хамтын нийгэмлэг» -ийн сэдвийг 70-аад оны дундуур идэвхтэй хэлэлцэх болжээ. Энэ үед Японы ерөнхий сайд байсан Такео Мики Номурагийн эрдэм шинжилгээний институтэд уг асуудлаар тусгай илтгэл бэлтгэх даалгавар өгч, уг илтгэлийг Мики огцорсоны дараахан 1978 оны 5-р сард боловсруулж гаргасан байна. Японы цогцолбор судалгаа хөгжүүлэх төв (НИРА)-ийн «XXI зуун» ажлын группын Хэвлэсэн «Японы стратеги XXI зуунд. Хямралыг хэр хэн давах вэ?» гэдэг номд энэ илтгэлийг оруулжээ.⁶

Номхон далайн сав газрын хамтын ажиллагаатай холбоотой асуудлыг судлах зөвлөлдөх тусгай ажлын группийг Японы ерөнхий сайд Масао Охира 1979 оны 3-р сард өөрийнхөө хэрэг эрхэлсэн газрын дэргэд байгуулснаар «Номхон далайн хамтын нийгэмлэг»-ийн санааг дахин идэвхтэй хэлэлцэх болов. Дээрх группийг мөдхөн гадаад яамны сайд болсон Сабура Окита толгойлсон юм. Уг групп урьдчилсан илтгэлээ 1979 оны 11-р сард, төгсгөлийн илтгэлээ 1980 оны 5-р сард боловсруулав. Зөвлөлдөх групп урьдчилсан илтгэлдээ «Номхон далайн цагирагийн хамтын нийгэмлэг» байгуулах санал тавьжээ.⁷ Илтгэлийн энэ санааг Японы ерөнхий сайд Австралид 1980 оны 1-р сард айлчлах үед Масао Охира, Австралийн ерөнхий сайд Малькольм Фрейзертэй хамт санаачилж 1980 оны 9-р сард Канберра хотноо зохиосон Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны семинар дээр хэрэгжүүлж эхэлсэн байна. Канберрад болсон семинарт бүс нутгийн хөгжингүй таван капиталист орон, АСЕАН-ийн таван орон (Индонез, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд), Өмнөд Солонгос болон Номхон далайн арлуудын орнуудын (Фиджи, Шинэ Гвинейн Папуа, Тонгийн нэг нэг төлөөлөгч) 12 төлөөлөгчид оролцжээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд гурван салбарын хүмүүс, тухайлбал үйлдвэр, худалдааны томоохон эрх баригчид (ихэвчлэн Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөлийн гишүүд, эрдэмтэд (гол төлөв Номхон далайн орнуудын худалдаа, хөгжлийн бага хурал (ПАФТАД)-ын гишүүд) ху-

вийн журмаар оролцсон төрийн албан хаагчид байв. Уг семинарт оролцогчид Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурлыг (ПЕКК) байгуулав. ПЕКК-ийн хоёрдугаар чуулган 1982 оны 6-р сард Бангкокт, гуравдугаар чуулган 1983 оны 11-р сард Бали аралд, дөрөвдүгээр чуулган 1985 оны 4-5-р сард Сеулд, тавдугаар чуулган 1986 оны 11-р сард Ванкуверт, зургадугаар чуулган 1988 оны 5-р сард Осакад хуралдаж, долдугаар чуулганыг 1989 оны эцсээр Веллингтон хотод хуралдуулах юм.

ПЕКК-ийн үйл ажиллагааг урагшлуулахын тулд эрчимтэй чармайж байгаа боловч энэ үйл ажиллагаа үргэлж жигд хэвийн явж ирсэнгүй. Тухайлбал бүс нутгийн зарим орнууд эхэндээ түүнийг онцын ойшоохгүй байв. Японы дэмждэг «чөлөөтэй нээлттэй бүс» нь Япон-Америкийн худалдааны зөрчлийг улам хүчтэй болгохоос болгоомжлохын тулд гадаад бодлого Атлантын далай, бүх нийтийг хамарсан асуудалд чиглүүлэн ирсэн АНУ-ын засгийн газар, ПЕКК бий болсоныг төдий л талархаагүй юм. Түүнчлэн АСЕАН-ын орнууд Номхон далайн бүс нутгийн байгууллага бий болсон нь Япон, АНУ мэтийн илүү хөгжилтэй орнуудтай харилцах харилцаанд тэдний хэлэлцээрийн эв санааны нэгдэл, хүчийг сулруулж болзошгүй гэж болгоомжилж байв. АСЕАН-ын орнууд бүс нутгийн хөгжингүй орнуудтай тус тусдаа хоёр талын яриа хэлэлцээр хийхийг илүү эрхэмлэж, Номхон далайн хөгжиж байгаа бусад орнуудыг (Латин Америк, Номхон далайн орнуудын орон) хэлэлцээний механизмд оролцуулах нь Япон, бусад хөгжингүй орноос АСЕАН-ын орнуудад үзүүлэх тусламжийн программыг хорогдуулж болзошгүй гэж үзэж байлаа. Ийм учраас «Номхон далайн хамтын нийгэмлэг» -ийн тухай санааг засгийн газруудын программд тусгаагүй байв. Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөл ч, газрын биш байдлаар л ажиллаж ирсэн билээ. Харин 1980-аад оны дундуур байдал нэлээд өөрчлөгдөв. Энэ үед АСЕАН ын орнуудын байр суурь зөөлөрч, Индонезийн гадаад яамны сайд Мохтар Кусумаатмаджагийн санаачилгаар Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны хамтын нийгэмлэгийн орнуудын гадаад яамны сайд нарын 1984 оны 7-р сард Джакартад болсон зөвлөлгөөний хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулсан билээ. АСЕАН-ын орнуудын байр суурь зөөлөрсөн нь 70—80-аад онд эдгээр оронд эдийн засгийн нэлээд өөрчлөлт болсоны улмаас энд дэлхийн эдийн засгийн үргэн «өсөлтийн нэг төв» бий болсоноос шалтгаалав. Номхон даайн орнуудын хамтын ажиллагааны үзэл санаанд хандах хандлага өөрчлөгдөхөд нөлөөлсөн бас нэг дорвитой хүчин зүйл бол АНУ-ын бодлого зарим талаараа өөрчлөгдсөн явдал юм. Номхон далайн бүс нутгийн стратегийн болон эдийн засгийн ач холбогдлоос шалтгаалан АНУ-г «Номхон далайн хамтын нийгэмлэг» -ийн үзэл санааг практик дээр идэвхтэй боловсруулахад оролцуулах болсон америкийн «Номхон далайн давалгааны» үзэл баримтлалын ерөнхий тоймыг АНУ-ын ерөнхийлөгч Рональд Рейган 1983 оны 11-р сард Японд айлчлахдаа Японы парламентад хэлсэн үгэндээ тодорхойлсон юм. Америкийн хандлага ингэж өөрчлөгдөхөд бүс нутгийн орнуудтай америкийн худалдаа, эдийн засгийн солилцоо нэмэгдсэн Номхон далайн сав газарт өрнөсөн эдийн засаг, технологийн үйл явцыг америкийн эдийн засгийн байр суурийг бэхжүүлэхэд ашиглахыг санаархсан, түүнчлэн дэлхий нийтийн эсрэг тэсрэг зөрчилтэй холбоо бүхий цэрэг, улс төрийн бодлого зэрэг эдийн засаг, улс төрийн дорвитой учир шалтгаан нөлөөлсөн билээ. ПЕКК болон Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөлийн ажиллагааг АНУ шинээр сонирхох болсныг практикийн хэд хэдэн алхам харуулав. Тухайлбал Ази, Номхон далайн бүс нутгийн хэргийг зо-

хицуулагч тусгай элчин сайдын тушаалыг бий болгон, 1984 оны 9-р сард Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны америкийн үндэсний хороог байгуулж, түүний бүрэл дэхүүнд АНУ-ын үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны төлөөлөгчдийн зэрэгцээгээр зохицуулагч элчин сайд Р. Фэрбэнкс, төрийн нарийн бичгийн даргын туслах П. Вулфовиц зэрэг захиргааны төлөөлөгчдийг оруулжээ. Тус хорооны үйл ажиллагааг хувийн фондууд, Үүний дотор Эйша фондейшн санхүүжүүлж байна. Бүс нутгийн хамтын ажиллагааны асуудалд сонирхол ихссэнийг Японы улс төрийн болон үйлдвэр, худалдааны бүлгийнхэн анхааралдаа авч, Ерөнхий сайдын хэрэг эрхлэх газрын дэргэдэх зөвлөлдөх дээр дурьдсан тусгай группийн үндсэн дээр 1981 онд Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны Японы үндэсний хороог байгуулсан билээ. Сабуро Окита даргалсан энэ хорооны бүрэлдэхүүнд үйлдвэр, худалдаа, шинжлэх ухаан, улс төрийн 50 орчим томоохон зүтгэлтэн оржээ. Түүнчлэн Японы олон улсын харилцааны институт анхнаасаа эхлэн Японы үндэсний хорооны нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэж эхэлсэн юм.

Японы ерөнхий сайд Ясухиро Накасонэ 1985 оны 1-р сард Номхон далайн арлын улсууд, Австрали, Шинэ Зеландад айлчлах үед Японоос «Номхон далайн хамтын ажиллагаа»-ны санааг шинэ маягаар үзэх болсон нь харагдлаа («хамтын нийгэмлэг» гэхээ больсоны тэмдэглэе). Хожим «Накасонэгийн номлол» гэж нэршсэн энэ шинэ үзлийг Японы ерөнхий сайд дараахь дөрвөн өгүүлбэрээр тодорхойлжээ. Үүнд:

1. Бүс нутгийн хамтын ажиллагаа нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-техникийн харилцааг хөгжүүлснээр хязгаарлагдах ёстой;

2. Ийм хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн санаачлагыг АСЕАН болон Номхон далайн арлын орнууд гаргавал зохино;

3. Хамтын ажиллагаанд бусад орнууд оролцох боломж байх ёстой;

4. Уг хамтын ажиллагааг ПЕКК болон Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөлийн нэгэнт бий болсон механизмаар дамжуулан хэрэгжүүлэх болно.⁸

«Номхон далайн хамтын ажиллагаа»-ны бодлогыг идэвхжүүлэх, ПЕКК болон япончууд удирдах байр суурь эзлэх болсон бүс нутгийн олон улсын бусад гурван байгууллагыг бэхжүүлэхэд «Накасоногийн номлол» чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Одоо үед ПЕКК-т 15 гишүүн оролцсон байна. Энэ нь бүс нутгийн хөгжингүй капиталист орон болох АНУ, Япон, Канад, Австрали, Шинэ Зеланд, АСЕАН-ын зургаан орон (1984 оноос эхлэн Бруней нэмэгдсэн), Хятад, Өмнөд Солонгос болон «бүс нутаг» нэрлэгдэгч «Хятадын Тайбейн хороо» гэдэг нэрээр элсүүлэн Тайван, Номхон далайн арлын орнууд билээ. ПЕКК нь бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээг бий болгоход чиглэсэн хэд хэдэн төслийг судалж хэрэгжүүлж байна. ПЕКК-ийн дээд бүтцийн байгууллага гэвэл бүх гишүүдийн зөвлөлгөөн, байнгын хороо, хэд хэдэн тусгай групп (эрдэсийн нөөц болон эрчим хүчний, загас агнуурын, шууд хөрөнгө оруулалт болон технологи дамжуулах, мал аж ахуйн болон үр тарианы үйлдвэрлэлийн г. з.), зохицуулах групп, Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны үндэсний хороод юм. «Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай мэдэгдэл» гаргаж, БНХАУ-ыг элсүүлснээрээ ПЕКК-т оролцогчдын улс төрийн хүрээг өргөтгөсөн 1986 оны 11-р сарын Ванкуверын зөвлөлгөөнийг ПЕКК-ийн нэгэн амжилт гэж үзэж болно. ПЕКК засгийн газрын биш чанартай, байгууллага болон хууль зүйн талаар хатуу тогтсон бүтэцгүй байдаг нь үзэл са-

нааг чөлөөтэй хэлэлцэх, байдлыг түргэн тогтворжуулах бололцоо олгож байгааг ПЕКК-ийн хөгжил, харуулж байна. «Эв нэгдлийг хангах Номхон далайн ийм өвөрмөц аргыг» үр ашиг муутай, ихээхэн цаг хугацаа шаарддаг гэж ПЕКК-ийн зарим гишүүд шүүмжилж байгаа боловч бүс нутгийн орнуудын хөгжлийн хэмжээ харилцан адилгүй, өөр өөр байгааг харгалзах боломж өгдөг яриа хэлэлцээний бодитой механизм бий болгосныг бүх нийтээр хүлээн зөвшөөрчээ. ПЕКК-ийн зорилго, бүтэц, үйл ажиллагааг тодорхойлсон «Ванкуверын мэдэгдлийг» ч бүрэн зөвшөөрчээ. Уг мэдэгдлийн оршил бол мөн чанараараа ПЕКК-ийн дүрэм юм. Эдийн засгийн хамтын ажиллагаа бол эдийн засгийн чөлөөтэй бөгөөд нээлттэй солилцоог үндэс болгох ёстой, ПЕКК-т оролцох эрх олохын тулд Номхон далайн бүс нутагт эдийн засгийн талаар эрчимтэй ажиллах хэрэгтэй гэж дурьдсан дээрх оршлын зарим зүйлийг анхаарууштай юм. Эдгээр зүйл болон гурван этгээд бүхий үндэсний хороо байгуулах шаардлага бол ПЕКК-т элсэх зайлшгүй болзол гэж үзэж болно. Тусгай группийн ажилд гишүүн биш орнуудын мэргэжилтнийг оролцуулж болдог байна. Олон улсын бусад байгууллага, гишүүн биш орнууд ПЕКК-ийн бүх гишүүдийн зөвлөлгөөнд «ажиглагч» буюу «зочны» байдлаар оролцож болно.

Одоогийн болон ирээдүйн төлөвийн зарим асуудал

ПЕКК-ийн зохион байгуулалтын бүтэц бэхжиж хөгжсөн нь бүс , нутгийн энэ шинэ бүлгийн хүчийг нэмэгдүүлсэн боловч ээдрээтэй олон асуудлыг бүрмөсөн шийдвэрлээгүй юм. ПЕКК-ийн гишүүн орнуудын эдийн засгийн болон нийгэм-улс төрийн байдал харилцан адилгүй байгааг харгалзвал эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тийм ч амаргүй бөгөөд нэлээд хугацаа хэрэгтэй. ПЕКК-ийн байнгын хороонд хийсэн маргааны үр дүнд ПЕКК-ийн цаашдын хөгжлийн зарим үндсэн асуудал тухайлбал гишүүн элсүүлэх, үйл ажиллагааг санхүүжүүлэх, гишүүн биш орнуудтай харилцах, нарийн бичгийн дарга нарын газрыг ажиллуулах гэх зэрэг асуудлын талаар тодорхой ойлголттой болж, байдал, тогтворжсон байна. Одоо Номхон далайд хамаарах Латин Америкийн хэсэг орон, тухайлбал Чили, Мексик, Колумби, Перуг ПЕКК-ийн гишүүнээр элсүүлэх асуудал тулгарч байна. Энэ зорилгоор Чили, Мексикт үндэсний хороо байгуулав. Зөвлөлт Холбоот Улсаас Ази, Номхон далайн чиглэлийн гадаад бодлогоо идэвхжүүлэхийг Владивосток хотноо илэрхийлж ПЕКК-ийн үйл ажиллагааг нэлээд сонирхож байна. Ванкувер, Осакад болсон ПЕКК-ийн зөвлөлгөөн, 1987 оны 10-р сард Сеулд болсон эрдсийн нөөц, эрчим хүчний ажлын группийн хуралдаанд Зөвлөлтийн төлөөлөгч ажиглагчаар оролцжээ. Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааны Зөвлөлтийн үндэсний хорооны дарга, Зөвлөлтийн улс төрийн томоохон зүтгэлтэн Е. Примаков 1988 онд Осакад болсон зөвлөлгөөнд байлцаж, Зөвлөлт Холбоот Улс Номхон далайн бүс нутгийн байгууллагад нэгдэж, уг бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа цаашид хөгжүүлэх эрмэлзэлтэй байгааг илэрхийлжээ⁹, ПЕКК-т шинэ гишүүн элсүүлэх асуудлыг Веллингтон хотод болох дараагийн зөвлөлгөөн хүртэл хойшлуулсан байна .

ПЕКК-ийн зүйл, ажиллагааг: гишүүн орнуудын үндэсний хороод санхүүжүүлж ирсэн нь эдийн засгийн талаар дорой гишүүн орнуудад санхүүгийн бэрхшээл учруулж байна. Сүүлийн жилүүдэд ПЕКК-ийн үйл ажиллагаа өргөжсөн нь санхүүгийн асуудлыг зохих хэмжээгээр хүндрүүлэв. Санхүүгийн асуудлыг шийдвэрлэх нь ПЕКК ийн гурван этгээд бүхий бүтцийг цаашид хөгжүүлэхэд тус дөхөм болох юм. Ийм учраас ПЕКК-ийн бүх гишүүдээс татвар татаж, Ном-

хон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааны фонд (20 сая америк доллар) байгуулах тухай саналыг Японы үндэсний хороо 1986 оны 8-р сард гаргажээ. Тухайн үедээ энэ саналыг таашааж үзээгүй боловч 1987 оны 9-р сард Осакад болсон ПЕКК-ийн байнгын хорооны чуулганаас гишүүн бүр ПЕКК-ийн төв фондод жил бүр тодорхой хэмжээний татвар оруулж, 1991 онд 1 сая америк долларын фондтой болох тухай шийдвэр гаргав. Түүнчлэн ПЕКК-ийн гишүүн бүр өөрийн нэмэгдэл фонд бий болгож, хариуцсан арга хэмжээгээ санхүүжүүлж байх талаар зарчмын хувьд тохиролцсон билээ. Энэ нь ПЕКК-т оролцогчдод санхүүгийн нэлээд дарамт учруулах нь мэдээж юм. Гэвч ПЕКК-ийн төв фонд байгуулах явдал уг байгууллагын ажлыг тогтворжуулж, тодорхой чиглэлтэй болгох боломж олгох ёстой. Тус байгууллагын үйл ажиллагааны механизм, зохицлыг сайжруулах тулд байнгын нарийн бичгийн дарга нарын газар байгуулах тухай асуудлыг ч хэлэлцэж байна. Энэ асуудлыг япончууд идэвхтэй дэмжиж байгаа юм.¹⁰

ПЕКК нь засгийн газрын биш өвөрмөц бүтэцтэй, түүнд бүс нутгийн түргэн хөгжиж байгаа орнууд оролцдог, мөн эдгээр орнууд дэлхийн улс төр, эдийн засагт дорвитой байр суурь эзэлдэг зэргийг анхаарч үзвэл ПЕКК бол Номхон далайн бүс нутагт олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх ирээдүй бүхий хэлбэр мөн гэж хэлж болно. Японы ерөнхий сайд 1985 онд дэвшүүлж, 1986 оны «Ванкуверын мэдээлэлд» зарим талаар бататгасан хоёр зарчим нь бидний үзэж байгаагаар ПЕКК-ийг цаашид хөгжүүлэхэд чухал алхам болох ёстой. Уг хоёр зарчим бол зөвхөн эдийн засаг, технологийн хүрээнд л хамтран ажиллах, нийтэд хаалга нээлттэй байх зарчим юм. Эдгээр зарчим нь ПЕКК-ийн үйл ажиллагааг ганцхан энх тайвны зорилгод чиглүүлж, оролцогч орон бүрийн үндэсний ашиг сонирхлыг харгалзах бололцоо олгохоос гадна нийгмийн янз бүрийн байгуулалтай орнууд, бага орнууд ПЕКК-т оролцох бололцоог хялбарчилж байна. Түүнчлэн ПЕКК-ийн хүрээний эдийн засгийн хамтын ажиллагаа дан ганц худалдаа, технологи, хөрөнгө оруулалт зэрэг асуудлаас хальж, шинжлэх ухаан-техникийн дэвшил, соёл, боловсрол, хүрээлж байгаа орчны хамгаалал, тээвэр, телевиз, жуулчлалын өргөн хүрээтэй асуудлыг хамрахыг харгалзах ёстой.

БНМАУ-ын олон улсын эдийн засаг, улс төрийн харилцааг олон талтай болгох, Ази, Номхон далайн бүс газарт түүний явуулах бодлогыг идэвхжүүлэх, тус бүс нутаг дахь үйл ажиллагаанд эдийн засгийн талаар оролцох шаардлагын үүднээс тус бүс нутгийн засгийн газрын болон засгийн газрын биш байгууллагад оролцох хэрэгтэй болж байна. ПЕКК засгийн газрын биш шинжтэй байгаа нь түүнтэй хамтран ажиллах бололцоог хөнгөвчилж байна. Ийм хамтын ажиллагааг зохицуулахын тулд гурван этгээд бүхий бүтэцтэй, тухайлбал худалдаа-эдийн засгийн байгууллагын төлөөлөгчид, эрдэмтэд, улс төрийн зүтгэлтнүүд оролцсон үндэсний хороо байгуулах шаардлагатай. Эхний үед монголын төлөөлөгчид эрдэсийн нөөцийн болон эрчим хүчний, мал аж ахуйн, үр тариа үйлдвэрлэлийн мэргэжилтний тусгай болон ажлын групп, бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны үзэл баримтлалын асуудал эрхэлсэн ажлын группийн хуралдаанд оролцож болох юм. «Бага алхамын» бодлого хэрэг-

жүүлснээр харьцангуй богино хугацааны дотор Ази, Номхон далайн бүс нутгийн бусад оронтой эдийн засгийн үр бүтээлт харилцаа тогтоох талаар тодорхой үр дүнд хүрэх боломж байна.

АСЕАН-НЫ ОРНУУДЫН ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН АСУУДАЛД

Ч. Сувд

Сүүлийн үед «Шинэ үйлдвэржүүлэлтийн» хийгээд «Азийн залуу луунууд» хэмээн янз бүрээр нэрлэгдэж байгаа АСЕАН-ны орнууд олон улсын мэргэжилтэн, шинжлэн судлаачдын анхаарлыг гойд татах боллоо. Энэ нь санамсаргүй тохиолдол, өнгөц шохоорхол төдийхөн бус, харин ч зүй ёсны хэд хэдэн учир шалтгаантай, үлгэр жишээ авахуйц дууриалалтайд байгаа билээ.

Нийгмийн амьдралын бүх хүрээнд, тэр дундаас гадаад харилцаанд өөрчлөлт шинэчлэлт хийх зарчмыг дэвшүүлсэн МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын (1988 оны) үзэл санааны үүднээс үзэх юм бол АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлт нь манай орны хувьд тэргүүн туршлагын ч, үзүүлэх сургуулийн ч шинжтэй юм. Мэдээжээр манай орон нийгмийн байгуулал, газар зүйн байрлал, түүхэн уламжлал зэргээрээ АСЕАН-ны орнуудаас ихээхэн ялгаатай, гэхдээ хөгжиж яваа социалист орны аж үйлдвэржиж эхэлсэн орны хувьд адилсах тал, жиших зүйл байгаа нь эргэлзээгүй.

МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын тогтоолд «...дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд оновчтой оролцох замаар гадаад харилцаа ны үр өгөөжийг дээшлүүлэх нь чухал. гадаад бодлогын үйл ажиллагаанд тунхаглах, үзэл суртал, бусад ялгааг шалтаг болгох явдлыг

1. Мировая экономика и международные отношения, 1981, № 3, с. 73
2. Энэ тухай Kojima K, Japan and a Pacific Trade Area, Tokyo, 1971 - хэмээх номноос тодруулж үзнэ үү.
3. Kaneko K. A New Pacific Initiative: Strengthening the PECC Process. - Japan Review of International Affairs, Spring-Summer 1988, volume 2, n 1, p. 69
4. Энэ тухай «Тихоокеанское сообщество»: планы и перспективы, Москва, 1987, с. 70-86 тодруулж үзнэ үү.
5. An Asian-Pacific Regional Economic Organization: An Exploratory Concept Paper. Washington: US Government Printing Office. 1979, p. 19
6. «Тихоокеанское сообщество»: планы перспективы, Москва, 1987. с. 72
7. Interim Report on the Pacific Basin Cooperation Concept. Tokyo, 1979, p. 11
8. Nishikawa J. Towards Intensified Functional Cooperation in the Asia-Pacific Region. - The Challenge of Asia-Pacific Cooperation. Ed. by Fu-chen Lo, Kamal Salih. Association of Development Research and Training Institutes of Asia and the Pacific (ADIPA), Kuala Lumpur, 1987, p. 27
9. Far Eastern Economic Review, June 2, 1988, Volume 140, n 22, p. 59
10. Kaneko K., op. cit., p, 74-85